



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/54

Хөхбүрд

- Г Мэргэн 4 дүгээр багийн нутаг “Ар гуугын худаг” нэртэй газарт Үхэрт Боом өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.3, 15.4, 15.5, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4, 19 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Мэргэн 4 дүгээр багийн нутаг “Ар гуугын худаг” нэртэй газарт Үхэрт Боом өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:Ж.Ёндонпил (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Ж.Жамъяндагва (Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч)

С.Отгонжаргал (Эрүүл мэндийн төвийн дарга)

Д.Отгонцэцэг (Санхүүгийн албаны дарга)

Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ё.Дамдинпүрэв (4 дүгээр багийн Засаг дарга)

Л.Сэргэлэн (Асгама хоршоо малын эмч)

Б.Энхмөнх (Тамгын газрын жолооч)

Сумын мэргэжлийн анги бүрэлдэхүүн

3.Хязгаарлалтын дэглэм тогтоосон хугацаанд Худгийн өвөр, Бөмбөгөр толгой, Талын толгой орчмын нутаг дэвсгэрийн бүсээс гарах мал, амьтны,

642501021

D/2025/Засаг даргын захирамж А4.docx

тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хориглож ажиллахыг ажлын хэсэгт хариуцуулсугай.

4.Хил залгаа багууд нутаг дэвсгэрт ойр орчим хаваржиж буй малчдын малд үзлэг, ариутгал халдваргүйтгэл хийх, мөн хүний эрүүл мэндэд үзлэг хийх сэжигтэй шинж тэмдэг илэрвэл сумын Онцгой байдлын штабт цаг тухайд нь мэдээлж ажиллахыг, "Асгамба" хоршооны малын их эмч (Л.Сэргэлэн) багийн хүний эмч (Н.Мөнх-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

5.Боом өвчний талаар малчид мал бүхий иргэдийг мэдээ мэдээллээр хангаж, тандалт судалгаа хийж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасагт даалгасугай.

6.Онцгой байдал зарласан хугацаанд шаардагдах зардлыг Засаг даргын нөөцөөс 500,000 (Таван зуун мянган) төгрөгийг санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), нягтлан бодогч (Л.Алимаа)-д зөвшөөрсүгэй.

7.Хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тайлан мэдээг тухай бүр гаргаж, холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (М.Жавзансүрэнд)-д хариуцуулсугай.

8.Дээрх ажлын хэсгийн аюулгүй байдлыг хангаж хэв журам сахиулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч цагдаагын ахмад (С.Дашдондов), цагдаагийн дэд ахлагч (Р.Содном), экологийн асуудал хариуцсан байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч (Д.Азбаяр) нарт даалгасугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, захирамжийн заалтуудыг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан малчид, иргэдийг холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БЯМБАДОРЖ

